



ХЭНТИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
АРВАНТАВДУГААР ХУРАЛДААНЫ  
ТОГТООЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 04

Чингис хот

Г Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн дүнгийн тухай

Монгол Улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлийн 48.1, 48.2 дахь хэсэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.10.3 дахь заалтыг тус тус үндэслэн аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Арвантавдугаар Хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Аймгийн Засаг даргын 2022 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэсүгэй.
2. Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн талаар иргэд, олон нийтэд сурталчлан ажиллахыг аймгийн Засаг дарга /Ц.Чогсомжав/-д үүрэг болгосугай.





ХЭНТИЙ АЙМГИЙН  
ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН  
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛ

2022 оны 12 сарын 05 өдөр

Дугаар 15

Өндөрхан

ТЭМДЭГЛЭЛИЙН ХЭСГЭЭС

Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн  
хэрэгжилтийн дүнгийн тухай

Ц.Чогсомжав: /Хэнтий аймгийн Засаг дарга/ Үйл ажиллагааныхаа тайланг  
илтгэв.

Г.Хэрлэнчулун: /Хурлын дарга/ Илтгэлтэй холбогдуулж асуух асуулттай  
Төлөөлөгчид байна уу?

Ш.Шинэбаяр: /Төлөөлөгч/: Хүүхэд хөгжил хамгааллын жил болгон  
зарласан. Тэгвэл үр дүн нь хүүхдэд хэрхэн үр өгөөжтэй нөлөөлсөн бэ?

Ц.Чогсомжав: /Хэнтий аймгийн Засаг дарга/ 2022 оныг Хэнтий аймаг  
Хүүхэд хөгжил хамгааллын жил болгон зарлаж нэлээдгүй хүүхэд рүү чиглэсэн ажил  
хийж хэрэгжүүлж дууслаа. Жилийн эцсийн тайланг дараагийн хурал дээр ярина.  
Цаашдаа 2024 он дуустал үргэжлүүлээд дахин хүүхэд хөгжил хамгааллын жил  
болгон зарлах болно.

М.Шүрэнцэцэг: /Төлөөлөгч/ Мөрийн хөтөлбөрийг дүгнэсэн хүснэгтийг  
яагаад ирүүлээгүй вэ? Хөтөлбөрийн үр дүнг дүгнэсэн зүйл байна уу?

Ц.Чогсомжав: /Хэнтий аймгийн Засаг дарга/ Аймгийн засаг даргын мөрийн  
хөтөлбөр 6 бүлэг, 142 зүйтэй. Биелэлт 91.6 хувьтай байна.

Н.Алтангэрэл: /Төлөөлөгч/ Газар тариалангийн бүс нутагт талбайг зарах,  
бусдад шилжүүлэх тохиолдол гарч байгаа. Энэ асуудал дээр ямар арга хэмжээ авч  
ажилласан бэ?

Б.Дарханбаатар: /АЗДТГ-ын Хууль эрх зүйн хэлтсийн дарга/: Ажлын  
хэсэг тариалангийн бусуудэд хяналт шалгалт хийж ажилласан. Илэрсэн  
зөрчлүүдийг бүгдийг нь шалгаж зөрчилгүй болгосон. Байгаль орчны үнэлгээ,  
хөрсний шинжилгээ хийлгээгүй бол газар эзэмших эрхийг нь цуцалж байгаа.

О.Мөнхбаяр: /Төлөөлөгч/ Үйлдвэр ихээр барьж байж эдийн засгаа өсгөх  
боломжтой. Үйлдвэр барих ямар боломжууд байна вэ?

**Ц.Чогсомжав: /Хэнтий аймгийн Засаг дарга/ Газар асуудалтай. Мөн ажиллах хүч, эдийн засгийн боломж бүрдэхэд хүндрэлтэй байна.**

**Г.Хэрлэнчулуун: /Хурлын дарга/ Асуултаа таслах төлөөлөгчид саналаа хураая.**

Дэмжсэн-100%, Татгалзсан-0 , Түдгэлzsэн-0

**Г.Хэрлэнчулуун:/Хурлын дарга/ Санал хэлэх Төлөөлөгчид гараа өргөнө үү.**

**Г.Батгэрэл: /Төлөөлөгч/ Инженерийн шугам сүлжээ, цэвэрлэх байгууламж барьж байгаа энэ үед инженер бэлтгэх хэрэгтэй байна. Барилгын инженэр бэлтгэж аймагтаа чанартай барилга бариулмаар байна.**

**Д.Мөнх-Од: /Төлөөлөгч/ Улсын зөвлөгөөнийг манай суманд зохион байгуулах нь ихдэж байна. Олон зочдын хоол, буудал гээд зардалыг сумын төсвөөс гаргаж байгаа учраас энэ асуудал дээр зохицуулалт хийх хэрэгтэй байна.**

**Л.Мэндбаяр: /Төлөөлөгч/ Эрүүл мэндийн салбарт нарийн мэргэжлийн эмч, сувилагчийг багаар нь гадаад улс руу туршлага судлуулах хөтөлбөрт хамруулах хэрэгтэй байна. Мөн сувилагч, эмч нарын нийгмийн баталгааг хангаж байж дутагдалтай байгаа орон тоог нөхөж чадна.**

**Г.Хэрлэнчулуун:/Хурлын дарга/ Саналаа хаая гэсэн Төлөөлөгчид саналаа хураая.**

Дэмжсэн-100%, Татгалзсан-0 , Түдгэлzsэн-0

Тогоолын төслийг Аймгийн Засаг дарга Ц.Чогсомжав уншиж танилцууллаа.

**Г.Хэрлэнчулуун:/Хурлын дарга/ Тогоолын төслийг бүхэлд нь дэмжиж байгаа төлөөлөгчид саналаа өгнө үү!**

Дэмжсэн-100%, Татгалзсан-0 , Түдгэлzsэн-0

#### **ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:4**

**Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийг “тодорхой үр дүнд хүрсэн” гэж дүгнэж тогтоолыг Төлөөлөгчдийн 100 хувийн саналаар дэмжиж батлав.**



**АЙМГИЙН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРЛЫН АЖЛЫН АЛБА**